



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/80

Чингис хот

**Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай**

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу өвөлжөө,хаваржааны зориулалттай газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан Ө.Золзаяа,Ч.Хэрлэнбаяр холбогдох бичиг баримтыг үндэслэн газар эзэмших эрхийн гэрчилгээг 1 дүгээр хавсралтад дурдсанаар 2 иргэний 3 нэгж талбарыг шилжүүлсүгэй.


2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэдэд газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын мэргэжилтэн (Ц.Зулжаргал)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2023 оны 265, 2022 оны 55, 2023 оны 27 тоот захирамжийн дээрх иргэдэд холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР



Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны
07 дугаар сарын 07-ны өдрийн 180 тоот
захирамжийн хавсралт

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх нэрсийн жагсаалт

д/д	Шилжүүлсэн хүний эцэг/эх/-ийн нэр, нэр	Газрын зориулалт	Газрын хэмжээ	Эзэмшил газрын байршил	Шилжүүлэн авсан иргэн ААНБ-ын нэр	Хугацаа	Шилжүүлэх үндэслэл
1	Ө.Золзаяа	Өвөлжөө, хаваржаа	10000	Хэнтий, Хэрлэн 8-р баг, Хуучин сүрэгийн худаг	А.Цогтбаатар	28	Эрх шилжүүлэх гэрээ
2	Ч.Хэрлэнбаяр	Өвөлжөө хаваржаа	9972	Хэнтий, Хэрлэн 8-р баг Сондуултын адаг	П.Хэрлэн-Ундрах	6	Эрх шилжүүлэх гэрээ
3	Ч.Хэрлэнбаяр	Өвөлжөө хаваржаа	9971	Хэнтий, Хэрлэн 8-р баг Сондуултын гозгор	П.Хэрлэн-Ундрах	6	Эрх шилжүүлэх гэрээ